МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,149.049... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.06.21. Лхагва. №120 (4734) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН ТӨЛБӨРИЙГ НЭМЭХГҮЙ ГЭВ

II нүүрт

ДЭЛХИЙ

ХОЙД СОЛОНГОСТ ХОРИГДОЖ БУЙ ИРГЭДЭЭ СУЛЛАХЫГ ШААРДЛАА

VI нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +23
Шөнө +8

Дугаарын 60 мөр

## Сонгуулийн шоу битгий байгаасай

Г.ГАНЧИМЭГ

Монгол Улсын Төвбанк мөнгөний бодлогын хүүгээ хоёр хувиар бууруулж, 12 хувь болголоо. Үүний дараа их, дээд сургуулийн сургалтын төлбөрийг нэмэхгүй, шатахууны үнийг өсгөхгүй гэв. Бүр утааны голомтод он удаан жил амьдарсан гэр хорооллын иргэдээ гэнэт олж харсан юм шиг хачин гоё амлалтаар пологтуулж орхив, энэ өдрүүдэд. Нийслэлийн хамгийн их утаатай хэсэгт буюу Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүргийн гэр хороололд амьдардаг иргэдийг ямар ч урьдчилгаа төлбөр нэхэж зовоохгүйгээр ипотекийн зээлд хамруулж оосор бүчгүй орд цагаан өргөөнд амьдруулахаар шийдсэнээ Улаанбаатар хотын захирагч С.Батболд баяр бахдалтайгаар мэдэгдсэн юм.

Үргэлжлэл нь III нүүрт

# БАРЬЦААТ ЗЭЭЛ, БАНК БУСЫНХАН БАШИЙЦГААЖ БАЙНА




Х.НОРЖИН

Эдийн засаг хямрахын хэрээр ашиг орлого нь нэмэгдэж байдаг салбар бол банк бус санхүүгийн байгууллага. Бас хэн дуртай нь хөл тавьж чаддаггүй бизнес. Дэнчингийн хэмжээ нь өндөр, тэрбумаар яригддаг учраас тэр биз. Босго оноо буюу хөрөнгийн сангийн хэмжээ 2.5 тэрбум төгрөг юм билээ. Ийм хэмжээний бэлэн мөнгөтэй хүн хэд билээ хэмээн бодож, асуудлыг хөндөлгүй орхиж болох ч он гарсаар 30 орчим бичил санхүүгийн байгууллага шинээр байгуулагдаж, тамга тэмдгээ авсан тухай статистик тоон мэдээлэл сонирхлыг минь өөрийн эрхгүй татав.

Үргэлжлэл нь III нүүрт

СОНГУУЛЬ-2017

## Төрийн тэнцвэрийг хадгалахын төлөө Х.Баттулгыг дэмжинэ гэв

Н.ПУНЦАГБОЛД

Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Халтмаагийн Баттулга нийслэлийн иргэд, сонгогчидтой уулзалт хийж, мөрийн хөтөлбөрөө танилцуулж байна. Өнгөрөгч даваа гарагт Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн ард иргэдтэй уулзсан тэрбээр өчигдөр Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ажилласан юм. Халуу шатсан зуны өдрүүдийг үлдэн хөөж, ган тайлсан хур бороотой эдгээр өдрүүдийг үл ажран ажиллаж, сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш эхний 12 хоногт 8163 км зам туулж, 21 аймгаа бүтэн тойрч, хоёр хот, дөрвөн суурин, 20 гаруй сумдаар явж, 150 мянга гаруй хүнтэй биечлэн уулзжээ. Харин сүүлийн хоёр өдөрт нийслэлийн зургаан дүүрэгт мөрийн хөтөлбөрөө танилцууллаа. Харин өнөөдөр Багануур дүүрэгт ажиллах юм байна.

Үргэлжлэл нь IV нүүрт




СЭРЭМЖЛҮҮЛЭГ

# ҮЕР БОЛОХ ЭРСДЭЛТЭЙГ ИРГЭДЭД САНУУЛЛАА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ЭРХЭС

Даваа гарагийн шөнөөс эхлэн орсон борооны улмаас гудамж, зам, талбайд их хэмжээний ус тогтож, үер болох эрсдэл нэмэгдсэн талаар холбогдох албаныхан сануулж, сэрэмжлүүлэг хүргүүлж байна. Мөн өчигдөр шөнийн 00.00 цаг хүртэл онцгой байдал тогтоогоод байсан юм. Тэгвэл үргэлжлэн орсон борооны улмаас өчигдөр чамгүй олон газарт автозамын түгжрэл үүсч, автозам усанд автав. Тодруулбал, Баянзүрх дүүргийн нутаг E mart худалдааны төвийн уулзвар, Сүхбаатар дүүргийн нутаг 100 айлаас хойш Иргэний бүртгэлийн ерөнхий газар хүртэл, 100 айлаас зүүн тийш Сэлэнгэ зочид буудал, 10 дугаар хорооллоос нэгдүгээр хороолол, арын зам дагуух автозамууд, Саппоро төвийн уулзвараас Хорооллын эцэс, Бөмбөгөр худалдааны төв, Гэсэр сүмийн уулзварын авто замуудад их хэмжээний ус тогтсоны улмаас хөдөлгөөн удааширч, түгжрэл саатал бий болж байлаа. Мөн Үндсэний соёл амралтын хүрээлэнгийн баруун урд байрлах Нүхэн гарцнаас Дунд голын салдаг уулзвар хүртэлх автозамын хөдөлгөөнийг түр хугацаагаар хаасан гэдгийг Замын цагдаагийн албанаас мэдэгдэв.

Тэгвэл ирэх сарын эхээр ч гэсэн хур тунадас ихээр унах төлөвтэй байгаа аж. Мөн үргэлжилсэн бороо хэт хатсан хөрсөнд шингэж чадахгүй байгаа учраас үер болох магадлалтай байгааг албаныхан санууллаа. Зарим газарт ус ихээр тогтож үерийн нөхцөл байдал үүсч эхэллээ. Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс авсан урьдчилсан мэдээгээр зургадугаар сарын сүүл, долдугаар сарын эхээр үргэлжилсэн бороо орох төлөвтэй байгаа тул гол, мөрний арал, ай сав, уулын ам, үерийн замд буудалсан иргэд эрсдэлтэй газраас нэн даруй нүүж аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авах, усны түвшин нэмэгдэх тул бага насны хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, батлагдаагүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, амралт, аялал зугаалгыг цаг агаарын нөхцөл байдлыг судлаж зөв тооцоолох, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол, мөрний усанд орохгүй байх зэргийг анхаарч усанд осолдох аюулаас урьдчилан сэргийлэхийг Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс сэрэмжлүүллээ. Өчигдрийн байдлаар Онцгой байдлын газарт үертэй холбоотой дуудлага 50 гаруй иржээ.

ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2355.00 | 2369.00 | ФУНТ | 2948.00 | 3052.00 |
| ЕВРО | 2594.00 | 2655.00 | РУБЛЬ | 39.30 | 41.40 |
| ИЕН | 20.92 | 21.31 | ЮАНЬ | 342.00 | 347.60 |

Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2350.00 | 2367.00 | ФУНТ | 2960.00 | 3040.00 |
| ЕВРО | 2592.00 | 2663.00 | РУБЛЬ | 39.23 | 42.18 |
| ИЕН | 20.81 | 21.40 | ЮАНЬ | 343.00 | 347.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## УИХ-ын гишүүн Д.Гантулга, дэд сайд Б.Цогтгэрэл нарыг цагдаад өгчээ

Өчигдөр Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Туваан Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст УИХ-ын гишүүн Д.Гантулга, ХЗДХ-ийн дэд сайд Б.Энхбаяр, ЗТЯ-ны дэд сайд Б.Цогтгэрэл нарыг, Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгыг гүтгэсэн хэргээр шалгуулахаар өргөдөл өгчээ. Энэ үеэр Ардчилсан намын ЕНБД Ц.Туваан “Сүүлийн үед хэвлэл мэлээллийн хэрэгслээр УИХ-ын гишүүн Д.Гантулга, ХЗДХ-ийн дэд сайд Б.Энхбаяр нар манай нэр дэвшигчтэй холбоотой илт гүтгэсэн, хууль бус мэдээллийг цацах боллоо. Энэ асуудлыг хуулийн дагуу шалгаж өгч, үнэн зөвийг тогтоож өгөх хүсэлтийг манай нэр дэвшигч гаргасан. Тиймээс нэр дэвшигчийнхээ гаргасан өргөдлийг Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст хүлээлгэн өглөө” гэв. Мөн нэр дэвшигчтэй холбоотой хууль бус үйлдлүүдийг тухай бүрт нь шалгуулахаар цагдаагийн байгууллагад хандаж байгаа гэдгээ онцолж байлаа. Мөн АН-аас ЦЕГ болоод СЕХ-нд гомдол гаргаж байгаа юм байна. Энэ талаар Ардчилсан намын ЕНБД Ц.Туваан “Ардчилсан намын сонгуулийн штабын ухуулагчдыг цагдаагийн байгууллагаас баривчлах, шалгах, сурталчилгааны материалуудыг нь хураах авах гэх мэт үйлдэл гарсаар байна. Цагдаа хүчний байгууллагуудын зүгээс илт нэг талыг бариад хуулийн дагуу ажиллаж байгаа ухуулагчдын ажлыг хийлгэхгүй байгаа уг үйлдлийг шалгуулах өргөдөл, гомдлыг ЦЕГ, СЕХ-нд хүргүүллээ” хэмээсэн юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ЗАСГИЙН ГАЗАР

# Их дээд сургуулийн төлбөрийг НЭМЭХГҮЙ ГЭВ

Б.ТОГТОХ

*Засгийн газрын хуралдаан уламжлал ёсоор өчигдөр хуралдаж хэд хэдэн чухал шийдвэр гаргалаа. Тодруулбал, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын өмнөд хөршид айлчлахдаа олж ирсэн хоёр тэрбум юанын буцалтгүй тусламжийг гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулах шийдвэр гаргаснаас гадна, 2018 оны нэгдүгээр сараас тэтгэврийн доод хэмжээг 40-50 мянган төгрөгөөр нэмэх шийдэлд хүрчээ. Мөн энэ өдөр Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх салбар, олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч В.Пүрэвдоржийг эгүүлэн татаж, улмаар Швейцар улсад суух Элчин сайд Л.Пүрэвсүрэнг түүний оронд томиллоо. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг тоймлон хүргэе.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Тэтгэврийн доод хэмжээг 40–50 мянган төгрөгөөр нэмэгдүүлнэ

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын нэмэлт хэлэлцээрийн явцын талаар Засгийн газрын хуралдаанаар сонсч, ирэх 2018 онд ахмадын тэтгэврийн нэмэгдэлд 161 тэрбум төгрөг зарцуулахаар Засгийн газрын тогтоол батлав. Ирэх оны эхний өдрөөс эхлэн эхний ээлжинд бүрэн тэтгэврийн доод хэмжээг 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 300 мянгад, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 40 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 250 мянгад хүргэх, мөн 161 тэрбум төгрөгтөө багтааж бүх тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр 2018 оны улсын төсвийн төслийг боловсруулахыг холбогдох сайд нарт үүрэг болгосон юм.

### Бакалаврын орой, эчнээ, магистр, докторт суралцагчид “Оюутны хөгжлийн зээл”– д хамрагдана

Сургалтын төлбөрийн зээл олголтын өнөөгийн байдал, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг судалж, зээлд хамрагдах оюутны хамрах хүрээг өргөжүүлэх, зээлийн зарим нөхцөл, шаардлагыг хөнгөлөх, зээлийн үйлчилгээг шуурхай болгох зорилгоор Засгийн газар “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ыг шинэчлэн баталжээ. Ингэснээр “Оюутны хөгжлийн зээл”-д бакалаврын орой, эчнээ, магистр, докторт суралцагчид хамрагдах боломж бүрдэж байна. Мөн хүү бууруулах болон богино хугацааны зээлийг дээрх бүх түвшний суралцагч авах эрхтэй бөгөөд урт хугацааны зээлийг зөвхөн бакалаврын түвшнийхэн авах юм. Оюутны хөнгөлөлтийн зээлийг 38115 оюутан, суралцагч шинээр авна гэсэн тооцоо гарсан байна. Түүнчлэн 18 нас хүрээгүй оюутны батлан даагч нь үндсэн зээлдэгч байж болох өөрчлөлт оруулснаар 6000 оюутан зээл авах эрхтэй боллоо. Оршин суух харьяалал харгалзахгүйгээр зээл олгох болсноор орон нутгаас ирж суралцаж байгаа 87625 оюутан зээл авахын тулд заавал орон нутаг руугаа явах, эсвэл эцэг, эх, зээлийн баталгаа гаргасан хамтран зээлдэгч нь Улаанбаатар хотод ирэх шаардлагагүй боллоо. Зээлийн баталгааг малчин эцэг, эх гаргасан тохиолдолд зээлийг сар бүрээр хүү тооцож төлөх нөхцөлийг хөнгөрүүлж, малчны зээлийн эргэн төлөлтийн нөхцөлтэй ижил байх гэж нэмж тусгажээ. Оюутан, суралцагч зээл авахын тулд долоон төрлийн бичиг, баримт бүрдүүлж, нотариатаар баталгаажуулж байсныг цуцаллаа. Энэ мэдээллийг цахим хэлбэрээр банк бүр шалгаж байх боломжийг бүрдүүлснээр зээл авагч 3-7 хоног хэмнэх юм. Цаашид оюутны хөгжлийн зээлийг барьцаа хөрөнгөгүйгээр олгоход үүсэх эргэн төлөлтийн эрсдэлийг шийдвэрлэх банк, санхүүгийн механизм бий болгох, эргэн төлөлт, хуримтлалын хөрөнгөөрөө төсөвт ачаалалгүй, бие даан хөгжих сангийн талаар судалж, ирэх арваннэгдүгээр сард танилцуулахыг холбогдох сайд нарт үүрэг болгов. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор журмыг нь баталж арванхоёрдугаар сарын 25-ны өдрөөс сургалтын төлбөрийн зээл болох оюутны хөгжлийн зээл олгож эхэлсэн. Одоогийн байдлаар 1002 оюутан 1.6 тэрбум орчим төгрөгийн зээл аваад байгаа аж. Журамд өөрчлөлт оруулснаар энэ оны төсвөөс нэмэлт хөрөнгө гарахгүй. Энэ жил 82.7 тэрбум төгрөгийг оюутны хөгжлийн зээлд зарцуулах бөгөөд 41 мянган оюутан төлбөрийн ямар нэг дарамтгүй суралцах боломжтой болжээ.

### Буцалтгүй тусламжийг дахин төлөвлөлтөд зарцуулна гэв

Гэр хорооллын дахин төлөвлөлтөд БНХАУ-ын Засгийн газраас олгож буй хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламжийг зарцуулахаар Засгийн газраас шийдвэрлэлээ. Хоёр тэрбум юаниар Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг 75 хувиар бууруулна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулж инженерийн шугам сүлжээний ажлын зураг боловсруулж төсөвт өртгийг тогтоосон боловч улсын төсөвт хөрөнгө нь суугдаагүйн улмаас зогсоодбайсанболөнөөдөрийнхүү гацаанаас гарлаа. Ингэснээр барилгын ажил нь эрчимтэй явж байгаа ч дэд бүтцийн асуудал нь зогсоод байсан 15 байршил дахь 32.546 айлын орон сууцны хороолол, түүнийг дагасан сургууль цэцэрлэгүүд баригдаж ашиглалтад орохоор боллоо. Мөн орон сууцанд орох сонирхолгүй, өмчлөлийн газартаа оршин суух хүсэлтэй 10.336 айл, өрх байгаад зориулж тус бүр нь 200-250 айл өрх харьялагдах “Бичил дэд төв”-үүдийг байгуулж тэднийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох юм. Дэд бүтцийн эх үүсвэрийг эко байдлаар шийдэж сэргээгдэх эрчим хүч, био бичил цэвэрлэх байгууламж ашиглаж шийдвэрлэнэ. Мөн инженерийн хангамжийг төвлөрсөн, бие даасан болон холимог шийдлээр хангах юм. Үүнийг дагаж үйлчилгээний чиглэлээр тухайн “Бичил дэд төв” тус бүрийг дагаж 50-80 хүн ажилтай болж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх 100-150 ажлын байр мөн бий болно гэж тооцоолж байгаа аж. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ус, дулаан, цахилгаан эрчим хүчний асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх юм.

> ...Ирэх оны эхний өдрөөс эхлэн эхний ээлжинд бүрэн тэтгэврийн доод хэмжээг 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 300 мянгад, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 40 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 250 мянгад хүргэх, мөн 161 тэрбум төгрөгтөө багтааж бүх тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр 2018 оны улсын төсвийн төслийг боловсруулахыг холбогдох сайд нарт үүрэг болгосон юм...

### Сургуулиуд төлбөрөө нэмэхгүй

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын сургалтын төлбөрийг 2017-2018 оны хичээлийн жилд нэмэгдүүлэхгүй байх талаар зохион байгуулж буй арга хэмжээний үр дүнгийн талаар ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат танилцууллаа. Тус хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцээд Төрийн өмчийн их, дээд сургуулиуд 2017-2018 оны хичээлийн жилд бакалаврын сургалтын төлбөрийг нэмэгдүүлэхгүй байхаар шийдвэрлэжээ. Энэ хичээлийн жилийн тайлангаас үзэхэд төрийн өмчийн их дээд сургууль коллежийн бакалаврын сургалтын төлбөрийн дундаж хэмжээ 1-2.9 сая төгрөг байна. Үүнийг нэмэгдүүлэхгүй байхаар Засгийн газраас шийдвэрлэлээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Саналаа өгсөн иргэдэд тэмдэглэгээ хийхийг шаардлаа

АН сонгуулиар саналаа өгсөн хүмүүсийн хурууны хумсанд тусгай тэмдэглэгээ хийхийг СЕХ-ноос шаардаж албан бичиг хүргүүлжээ. Саналаа өгсөн сонгогчийн хуруунд тэмдэглэгээ хийх нь нэг сонгогч олон удаа санал өгөхөөс урьдчилан сэргийлдэг байна. Энэ зорилгоор Сонгуулийн тухай хуульд сонгууль зохион байгуулах зардалд сонгогчдын санал авах, тэднийг бүртгэх, сонгогчийг таньж оруулахад хэрэглэх тусгай тэмдэглэл хийх хэрэгслийг худалдан авах , тээвэрлэж хүргүүлэх зардал багтахаар хуульчилж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан байдаг байна. Гэтэл УИХ-ын 2016 оны сонгуулиар СЕХ тусгай тэмдэглэгээ хийх хэрэгслийг худалдаж аваагүй учраас хэрэглээгүй аж. Иймд 2017 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах ажиллагаанд тусгай тэмдэглэл хэрэглэж, улсын төсвийг зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай гэж Ардчилсан нам үзжээ.


СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ ХАЛТМААГИЙН БАТТУЛГЫН СОНГУУЛИЙН ШТАБ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Соёл амралтын хүрээлэн, Гэндэнгийн гудамж-16, 3 давхарт Ардчиллын өргөө Утас:11-339966, Факс:(976-11) 339966

2017.06.19 № 2/11

Тусгай тэмдэглэл ашиглах шаардлага хүргүүлэх тухай

Сонгуулийн тухай хуулийн 38.1-д зааснаар сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр баталдаг.

Сонгууль зохион байгуулах зардалд сонгогчдын санал авах буюу сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулахад хэрэглэх тусгай тэмдэглэл хийх хэрэгслийг худалдаж авах, тээвэрлэж хүргүүлэх зардал багтдаг.

Тусгай тэмдэглэгээ буюу гарын хурууны хумсанд хийх тусгай тэмдэглэгээ нь нэг сонгогч олон удаа санал өгөхөөс урьдчилан сэргийлдэг бөгөөд зохих зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж Сонгуулийн хуульд заажээ.

Тухайлбал Сонгуулийн тухай хуулийн 38.2-т "УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:... 38.2.7.санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал", 38.3-т "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, улсын бүртгэлийн байгууллагын төсөвт тусгана:...38.3.1.сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах... тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх,

Хуулиар тогтоосон зардлыг сонгуулийн зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулаагүйгээс үүдэн гарах хууль зүйн болон улс төрийн хариуцлагыг гагцхүү Сонгуулийн ерөнхий хороо хариуцах болно гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Хувийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Я.САНЖМЯТАВ

## Зөөврийн хайрцгаар санал авах хүсэлтийг хүлээн авч дуусчээ

Сонгуулийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу санал авах өдрийн өмнөх өдөр зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа болдог уламжлалтай. Тэгвэл зөөврийн хайрцгаар санал авах хүсэлтийг өчигдөр хүлээн авч дууслаа. Хуульд сонгууль болохоос тав хоногийн өмнө буюу зургадугаар сарын 21-нээс өмнө иргэд хүсэлтээ өөрийн харьяа хэсгийн хороо буюу санал авах байранд бичгээр хүргүүлэх учиртай. Тэгвэл зөөврийн хайрцгаар санал өгөх иргэд нь эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй, Дайчилгааны тухай хуульд заасны дагуу нийтийн дайчилгаанд хамран ажиллаж байгаа, Захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, Байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон, Санал авах ажиллагааг зохион байгуулж байгаа сонгуулийн байгууллагын ажилтан, цагдаа, иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэдээллийн технологийн даамал нар байдаг билээ.

## Ажил олгогчдын өдөрлөг борооноос болж хойшлов

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нээлтэй хаалганы өдөрлөг өчигдөр хоёр дахь өдрөө үргэлжлэх байсан ч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж цуцлагдлаа. Тодруулбал, нийслэлд орж буй ширүүн бороо өчигдөр бүтэн өдөржин үргэлжилсэн учраас ийн хойшлуулав. Өнгөрөгч даваа гарагт нээлтээ хийсэн тус өдөрлөгийн үеэр нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бүлгүүд, гэр бүл, хүн амын хөгжил, нийгмийн халамжийн зэрэг олон талт бодлого, хууль эрх зүйн танилцуулга, арга хэмжээ, үйлчилгээг иргэдэд өгч ажилласан юм. Өдөрлөгт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудаас ХНХЯ-ны харьяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж, иргэдийн асуулт, лавлагаанд хариу өгч, дэлгэрэнгүй мэдээллийг хүргэсэн. Мөн харьяа байгууллага, судалгааны төвүүдээс гадна ажил олгогч томоохон аж ахуйн нэгжүүд ч өдөрлөгт оролцож иргэдийг нээлттэй ажлын байранд сонгож авах ажлыг зохион байгуулсан билээ. Өдөрлөгийн үеэр хамгийн том хөдөлмөрийн бирж ажиллаж 20.000 ажлын байранд 60 орчим аж ахуйн нэгжүүд иргэдийг бүртгэх ажлыг зохион байгуулсан юм. Тэгвэл цаг агаарын нөхцөл байдал сайжирсны дараа энэхүү өдөрлөгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх бололтой.

# ҮЗЭЛ БОДОЛ



# БАРЬЦААТ ЗЭЭЛ, БАНК БУСЫНХАН БАШИЙЦГААЖ БАЙНА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Улсын хэмжээнд 2017 оны хагас жилийн байдлаар 245 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 105 нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг. Энэ бол гуравхан сая хүн амтай жижиг зах зээлд бага тоо биш. Дампуурч хаалгаа барьсан банк бус санхүүгийн байгууллагын тухай мэдээлэл байхгүй байгаа нь бүгд л ямар нэг байдлаар ашигтай ажиллаж байгааг нотлох баримт юм. Банк бус санхүүгийн байгууллагууд иргэнд тавих нөхцлөө зөөлрүүлэхийн хэрээр хүүгээ өсгөх бодлого баримталж буй. Барьцаалах хөрөнгөтэй л бол хаалга нь үргэлж нээлттэй байдаг энэ байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн тоо жилээс жилд бус сараас сард нэмэгдсээр байгаа нь ард түмний амьдрал тэр хэрээр доройтож байгаагийн илрэл байж мэднэ. Ядарч тэвдэхийн цагт толгойд хамгийн түрүүнд хүү өндөр ч бодлого нь уян хатан, явдал суудал багатай Банк бус санхүүгийн байгууллага санаанд буух нь бий. Тэгээд л хөл дүүжлэх унаанаасаа өгсүүлээд үнэ хүрэх бүхнээ барьж очин хэдэн төгрөг болгож аваад санаа амрах ч сарын дараа сахил аваад шал дордов гэгч болдог нь худлаа биш. Нөгөөтэйгүүр, банк бус санхүүгийн байгууллагаар хэн үйлчлүүлдэг вэ гэхээр банкны зээлээр орон сууц худалдаж авсан иргэд байдаг гэнэ лээ. Банк давхар зээлтэй иргэнд зээл өгөхгүй учраас очдог газар нь банк бус. Орон тооны цомхотгол, уул уурхай зогссоноос үүдэн хэдэн зуун мянган иргэн энэ байгууллагад байдгаа барьж очиж байгааг тоон баримт харуулж байх юм. Харамсалтай нь зээл авсан өдрөөс хүү бодогдож, банкны зээл дээр банк бус байгууллагын хүү өндөртэй зээл нэмэгдэнэ. Хойд хормойгоороо урдахаа нөхсөөр нэг өдөр таг зогсоно. Зарим нь ч яах вэ, яаж ийж байгаад учрыг нь олдог л байх. Харин банк бусууд өндөр хүү, өдрийн алданги хоёроороо хармаа хотоо түнтийлгэн, илүү ихийг олохын төлөө улайраад зогсохгүй хураасан эд хөрөнгөө өөрсдийн нэр дээр шилжүүлснээр хөрөнгөжиж эхэлдэг аж. Ерөөс байшин болгоны буланд ломбард, банк бус хоёр нээгдэж, нийслэлийн дүүрэг болгонд салбараа нээцгээн “дөвчигнөж” байна. Чамлахааргүй ашиг олсон зарим нь мөнгө угаах бас нэгэн хувилбар болох зээл чөлөөлдөг бизнесийг эрхэлдэг болсон байгаа талаар ядарсан иргэд гомдол мэдүүлэхээс өөр шид алга. Нөгөө нэг нь жижиг худалдаачдад өдрөөр мөнгө зээл олгоод оройд нь хүүтэйгээр эргүүлж авах жишээтэй. Бүр том “гарууд” нь газрын наймаа, барилгын бизнес рүү шилжинэ. Энэ бүхэн ард түмний нус нулимсан дунд цэцэглэж буй хэрэг. Мөн ийм аргаар мөнгө угаагчдын нэг нь дээр хэлсэнчлэн барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээ бүхий ломбардууд. Байшингийн булан тохой, үйлчилгээний байгууллагын үүдэнд голдуу төвхнөсөн ломбард банк бус санхүүгийн байгууллагын дэргэд эргэлтийн мөнгөөрөө чигчий хурууны дайтай ч төрийн албан хаагч, оюутан сурагчдын нэг удаагийн хэрэгцээг өлхөн хангачих чадалтай. Хүү нь ч өндөр 6-8 хувь. Сүүлийн үед сараас бус 7-10 хоногийн хугацаатайгаар зээлээ олгодог болсон гэж дуулдсан. Банкны зээлийн шалгуур улам л нарийсч, нийгмийн даатгалыг хүртэл лавлагаагаар нэхдэг болов. Арга ч үгүй. Хувь, хувьсгалын байгууллагуудын өр төлөөс нийгмийн даатгалын салбарт овоорчихсон учраас бичсэн дэвтэрт бус лавлагаанд итгэхийг илүүд үзэх болжээ, тэд. Тиймээс энэ сийхийгээр ломбард баяжих аж.

Ломбардуудыг цэгцлэх, хяналттай болгох тухай УИХ-ын гишүүд удаа дараа ярьж, хуулийн төсөл ч боловсруулж байв. Гэвч өнөө хэр ахиц гарсангүй. Энэ сиймхийг ломбардууд тун овжин ашиглаж, хотын төвд оффис барихаас наагуур л хөлжиж байх юм. Хугацаа хэтэрсэн хоногт тутамд алданги тооцохоо хамгийн сайн чадна. Зөвхөн нэг өдрийнх нь алданги мянган төгрөгөөс эхэлнэ. Тэр нь арван өдөр болоход үндсэн хүүтэйгээ нийлээд явж өгнө дөө. Бас үнэт зүйлийг нь хэрхэн үнэлэхээ биднээр заалгахгүй. Жишээ нь 150 мянган төгрөгийн үнэтэй бөгж байлаа гэхэд үнийн дүнгийн 70 хувиар үнэлнэ гээд 105 мянгаар үнэлж байгаа юм. Цаашлаад энд, тэнд нь иймзураач гарчихаж мэтээр өөлж гоочилсоор 60-70 мянган төгрөгөөр үнэлж орхино.

Тодорхой хугацааны дараа үнэт зүйлийг нь ашгаа хоёр нугалсан үнээр борлуулчихаад маадгархан суух. Үйлчлүүлэгч бид ч тэдний эл араншинг мэддэг ч мөнгөгүйн гайгаар аманд нь багтаж л суух юм, яалтай билээ. Нийгэмд зовлон зүдгүүр нүүрлэсэн үед зөвхөн лам баяждаг байсан бол эдүгээ Банк бус санхүүгийнхэн бас хуваалцдаг болжээ. Зуданд нохой зоолж, зовлонд лам баяждаг гэх үг өнөө цагт өнгө төрхөө өөрчилж ард түмэн хямрахад ломбард, банк бусчууд зоолдог болсон цөвүүн цаг иржээ. Эцэст нь өгүүлэхэд, Монгол Улс гадны улс орнуудад төлөх өрөө бус өртэй өрхөө тоолбол яасан юм бэ. Нэг айл лизин, ломбард, банк бус, байрны гээд хамгийн багадаа л хоёр гурван зээлтэй байна. Гэтэл авдаг цалин нь ахиж дээшилсэн юм алга. Төр засаг нь хаа нэгхэн цалин нэмлээ гэж шоудахаас өөр шидгүй суух. Ядахад яр гэгчээр, цалин тэтгэврийн хүүг бууруулж буян үйлдлээ хэмээдэг ч эсрэгээрээ банкны шалгуурыг улам нэмэгдүүлж, хүү буурах бус хүүгийн сарын хугацааг л бууруулж орхидог нь гачлантай юм. Мэргэн төрийн шийдвэр болгон монгол түмний амьдралд нэмэр биш нэрмээс болж буйг ойлгох сайн цагийг үзэхсэн.

> ...Зуданд нохой зоолж, зовлонд лам баяждаг гэх үг өнөө цагт өнгө төрхөө өөрчилж ард түмэн хямрахад ломбард, банк бусчууд зоолдог болсон цөвүүн цаг иржээ. Эцэст нь өгүүлэхэд, Монгол Улс гадны улс орнуудад төлөх өрөө бус өртэй өрхөө тоолбол яасан юм бэ. Нэг айл лизин, ломбард, банк бус, байрны гээд хамгийн багадаа л хоёр гурван зээлтэй байна. Гэтэл авдаг цалин нь ахиж дээшилсэн юм алга...

Дугаарын 60 мөр

## Сонгуулийн шоу битгий байгаасай

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Орон сууцанд орчихно, дээрээс нь “Ирэх намар хүүхдийн маань сургалтын төлбөр хэдэн хувиар нэмэгдэх бол” хэмээн толгой гашилгах хэрэггүй, бүр талх, бензиний үнэ өсчих вий хэмээн ахуй амьдралынхаа амьжиргааны асуудалд санаа зовохгүй сайн цаг ирж буй бололтой, Монголд. Энэ сайхан амлалтууд өчигдрийн орж эхэлсэн бороо шиг л үнэн байгаасай. “Энэ бороо чинь арай эвлүүлэг биш биз дээ” гэдэг егөө шиг сонгуулийн дараа “Өө, тэдгээр амлалт чинь эвлүүлэг байсан шүү дээ” гэж л битгий бултаасай билээ. Ард түмнээ номхон гэж ноолж, дуугүй юм гэж “хулхин дээр нь цэцэг ургуулж” ханадаггүй эвлүүлэгтэй улс төр өө гэж. Дундаж давхарга нь үгүй болтлоо дампуурсан Монгол Улсын нийгэм, эдийн засгийг өөд нь татах амлалтыг зөвхөн энэ удаад ч биш өмнө нь бас өгч л байлаа, эрх баригч хүчин. Тухайлбал, 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнө МАН-ынхан Монгол Улсын эдийн засгийг хямралаас гаргахын тулд төсвийг хэмнэлтийн горимт оруулж, алдагдлыг нь нөхөхийн тулд “Зээл авахаас татгалзана” гэж мэдэгдэж байлаа. Харин сонгуулийн дараа ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдаж 5.5 тэрбум ам.долларын зээлийн эрхтэй болж, Япон, Турк, Солонгос, Хятад зэрэг орноос зээл авахаар болов. Мөн “МАН ялбал дараагийн дөрвөн жилд шинээр татвар авахгүй, бас нэмэхгүй. Эсрэгээр нь бизнесийн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого баримтлах болно” гэж цагаан дээр тодоос тод хараар бичиж байлаа. Ялсан хойноо “Татварыг жоохон нэмэхгүй бол яасан ч болохгүй нь” гэж матрын нулимс унагааж байгаад л сонгогчидоо мадалж орхисон нь маргашгүй үнэн билээ. Хөөрхий, ядарсан иргэдийнхээ халаасыг тэмтэрч дайжигнахаа бас мартаагүй ээ. “Та нар биднийг дэмжиж сонговол цалин, тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлнэ. Дор хаяж 10-15 хувиар...” гэж ирээд л нүдэнд нь оч гэрэлтүүлж чадсан овсгоо самбаатай. Одоо харин цалин, тэтгэврээ нэмүүлэх нь байтугай “Хамаагүй юм ярьж байгаад ажлаасаа халагдчих вий” гэсэн айдас болгоомжлол ардчилсан Монголыг боомилж, ажил хийж ар гэрээ тэжээдэг залуус амандаа хэлээ хазан сууна. Ямар их гунигтай байна вэ, энэ жилийн зун. Хув хуурай, газрын хүйсээ хүртэл хатаж ангасан байгаль дэлхийн ганг хурмаст тайлж орхив, азаар. Харин Монгол төрийн албанд нүүрлэсэн ганг хэн хэзээ тайлах бол. Өнгөрсөн жилийн сонгуулиас хойш намын харьяаллаар ажлаас халдаг явдал гаарч, хот, хөдөөгүй л хэлмэгдүүлэлт эхэлсэн. Мөрөөрөө ажлаа хийж яваад гэнэт халагдаж, ажил амьдралгүй болсон иргэдийг орчин цагийн хэлмэгдүүлэлт өртсөн гэж үзэхгүй, өөр юуг хэлмэгдүүлэлт гэх юм бэ. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаатай уралдаж гарч ирсэн сайхан амлалтуудыг битүүхэн хардаж, “Сонгуулийн шоу биш л байгаасай” гэж ханцуй дотроо залбирч сууна, энэ Монголын чинь ядарсан иргэд. Ээ дээ, Монголын улс төр үү. Итгэхэд бэрх эд болоо шив дээ. Эхнэр хүүхдээрээ оролдож, элдэвлэхээс өөр шид алга.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# Төрийн тэнцвэрийг хадгалахын төлөө
# Х.БАТТУЛГЫГ ДЭМЖИНЭ ГЭВ

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**



Баянзүрхчүүд 12 хоног орон нутагт ажиллаад ирсэн түүнээс мэтгэлцээний талаар сонирхон асуух нь элбэг байв. Х.Баттулга нэр дэвшигч энэ асуултад “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ярьж, бичиж байгаа шиг мэтгэлцээнээс халгаж зугтаасан юм ер байхгүй ээ. Тэнгэрээр нисч яваа хүмүүс машинаар Монголоо тойрох ямар байдгийг мэдэхгүй. Мэдсэн ч мэтгэлцээнд дуудаж, айж зугтсан мэтээр ард иргэдэд ойлгуулж байна. Миний хувьд хийж бүтээсэн зүйл хэлэх үг ч байна. Миний зүгээс гүжир гүтгэлгээр бус бодлогоор өрсөлдье гэж ярьж, хэлж явлаа. Тиймдээ ч аймаг, орон нутгийн иргэдтэйгээ уулзъя, мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хэрэг. 12 хоногт хөдөөд ажиллаад ирсэн хойгуур оффшорт мөнгөтэй, мэтгэлцээнээс зугтсан гээд элдвээр гүжирдэж гүтгэлээ. Би өөрөө хоосон ярихаас урьдаар хийж, бүтээж харуулахыг хичээдэг. Тэр зангаараа чимээгүй л явж байна. Угаас идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургана гэх үгтэй. Хэн нь хэн болохыг цаг хугацаа харуулна байх аа” гэсэн юм. Мөн “Нийслэлийн оршин суугчдын дөрөвний нэг нь амьдардаг их хотын их дүүрэг болох баянзүрхчүүд та бүхэнтэйгээ уулзаж байгаадаа баяртай байна. Өнөөдөр баянзүрхчүүд засаглалгүй явж байгаа. Аравдугаар сард болсон орон нутгийн сонгуулиар эрх баригч нам ИТХ-ын 41 суудлаас 22-ыг нь алдчихаад эрх дархаар далайлган өдий хүрлээ. Энэ том дүүрэг засаглалгүй явж байгаа нь шударга явдал биш болов уу. Наранчулуун гэж танай дүүргээс гарсан залууг авч яваад хорьчихсон. Өөрийнхөө намд оруулах гэж улайрч байгаа нь тэр. Хийж чаддаг, мэддэг юм нь ердөө энэ болсон. Хуулийн байгууллагаар далайлган хүнийг айлгаж, гүтгэж, шоронд хорьж, намд элсүүлэх, хуйвалдах, хулгайлах талаар л ярьдаг болсон. Өнөөдөр Баянзүрх дүүргийн засаглалын энэ байдал, энэ хямрал Монгол Улсын ерөнхий дүр зургийг харуулж байна” гэлээ. Баянзүрх дүүргийн тухайд нийслэлийн хамгийн олон хүн амтай дүүрэг бөгөөд 3000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдардгаас нэр дэвшигч Х.Баттулгын уулзалтад 300 гаруй нь оролцсон юм. Тиймдээ ч тус дүүргийн уулзалтыг дохионы хэлмэрчээр дамжуулан дээрх иргэдэд хүргэсэн юм. Нэр дэвшигч Х.Баттулгын “Хүчирхэг Монголын төлөө” мөрийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг анхаарах тухай, өмнө нь анхаарч байсан гэх боловч үр дүнд хүрээгүй талаар, хэрхэн үр дүнтэй болгох тухай тодорхой дурдсан бөгөөд тэдний эрхийг дээдэлсэн хууль, эрхзүйн орчин бий болгох, нийгмийн харилцаанд оролцох боломжийг нь тэлэх зэрэг олон улсад хэрэгжсэн бодитой ажлуудыг тусгасан нь бий. Уулзалтын үеэр уулзаж

> ...Гэхдээ гүтгэлэг сөрж яваа эр хүн гүйж яваа морь хоёрт ялгаа байхгүй. Энэ хүн насан туршдаа өөрийнхөө гэрэл гэгээг бусдад түгээсэн. Урлаг спорт, түүх дурсгал, бизнесийн салбарт гараараа, зүрх сэтгэлээрээ байгуулсан гавьяа нь их ээ. Би ганцхан жишээ хэлье. 2000-аад оны эхэнд болов уу гэж бодож байна...



ярилцсан иргэдийн дунд орон нутгийн сонгуулийн тухайд санал бодлоо уламжлах нь олон байв. Хагас жил гаруй хугацаанд орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь хөлөө олохгүй бужигнаж, эрх баригч намын зүгээс элдэв дарамт учруулж байгаад бухимдалтай байгаа аж. Тиймдээ ч баянзүрхчүүд засаглалын хямралыг засч, төрийн тэнцвэрийг хадгалахын төлөө эх оронч Х.Баттулгыг дэмжинэ гэдгээ илэрхийлж байна. Уг уулзалтад УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл, Нийслэлийн Ардчилсан намын дарга Д.Баттулга, “Болор цом”-ын эзэн, яруу найрагч Ц.Хулан тэргүүтэй улс төр, урлаг соёлын төлөөлөл оролцлоо. Энэ үеэр Болор цомын эзэн, Яруу найрагч Ц.Хулан уулзалтад оролцож буй иргэдэд хандан үг хэлсэн юм. Тэрбээр “Улс төр ярих тийм ч таатай байдаггүй ээ. Яагаад гэвэл улс төрөөс бид байнга хараат байсаар ирж. Муухай зүйлийн тухай ярьснаас сайхан төмс арилгасан нь дээр байдаг. Муу улстөрчдийн тухай ярьснаас сайхан эгэл хүнтэй хөөрөлдөж суух нь амар. Халтмаагийн Баттулгын олон сайхан гавьяаг энд дурдаж болно. Гэхдээ гүтгэлэг сөрж яваа эр хүн гүйж яваа морь хоёрт ялгаа байхгүй. Энэ хүн насан туршдаа өөрийнхөө гэрэл гэгээг бусдад түгээсэн. Урлаг спорт, түүх дурсгал, бизнесийн салбарт гараараа, зүрх сэтгэлээрээ байгуулсан гавьяа нь их ээ. Би ганцхан жишээ хэлье. 2000-аад оны эхэнд болов уу гэж бодож байна. Монгол хүний хүнсний өдөр тутмын хэрэгцээ болсон мах, талхны үйлдвэрийг гадаадын капиталистуудаас, “Мах импекс”-ийг германчуудаас, “Талх чихэр”-ийг чехүүдээс энэ хүн бараг ганцаараа шахам хамгаалж, өнөө цагийн М.Энхболд мэтийн хуйвалдагч, хувь хүртэгсдээс хамгаалан авч үлдэж, Монгол Улсад, монгол хүнд хямд үнэтэй хүнс хэрэглүүлж буй гавьяа Баттулгынх юм. Ядахнаа үүнийх нь төлөө монгол хүн бүр Баттулгад талархах ёстой. Өнөөдөр алт ухаж, архи нэрж, гарын үсгээр баяжигчид төрд яасан олон болоо вэ. Тэд төрөө худалдаж олсон мөнгөөрөө ард түмний тархийг угааж байна. Сонгуулийн гүтгэлэг, пи-ар-ыг хийж байна. Үүнийг над шиг нам бус хүнээс сонсох нь дээр болов уу гэж бодсон юм. Ингээд баянзүрхчүүд минь ээ, ерөөс нийт Монголын ард түмээн сонор соргог байхтун. Манжийн дарлалыг сэгсрээд гарч ирж болсон юм хойно МАН-ын дарангуйллыг хялбархаан давж гарч чадна шүү. Ингэхийн тулд бид өнөөдөр бидэнд олдсон цорын ганц түүхэн боломжоо огтхон ч алдаж болохгүй. Энэ бол Халтмаагийн Баттулгыг энэ сонгуульд ялуулж, төрийн тэргүүнээр сонгож, төрөө тэнцүүлж, хяналттай болгох юм. Хаад ноёдын хүлэг биш харцын морь түрүүлэх болтугай, Монгол ялна” гэв.

## “Аж үйлдвэрийн ууган голомт, уурхайчдын үр сад эргэлзэхгүйгээр М.Энхболдыг дэмжинэ”



Аж үйлдвэрийн ууган голомт Налайх дүүргийнхэн төв талбайдаа хоёр мянгуулаа цуглаж МАН-аас Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболдыг угтан авлаа. Монгол түмнийхээ их итгэлийг хүлээж төрийн тэргүүн болбол түүний дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр налайхчуудад хамгийн давуу байдлыг бий болгоно. Учир нь, налайхчуудын ирээдүйн зорилт, төлөвлөгөө ажил хэрэг болоход дэмжлэг үзүүлэх олон бодлого, зохицуулалт “Монгол төр-Монгол гэр” мөрийн хөтөлбөрт багтсан байна. Нийслэлээс алс орших гурван дүүргээс Налайх хамгийн олон хүн амтай төдийгүй байгалийн баялаг ихтэй гэдгээрээ давуу. Жишээлбэл, иргэд нь алт, цагаан тугалга, болор, нүүрс, шохой, элс хайрга зэргээ ашигладаг. Анх 1912 онд нүүрс олборлож нийслэл рүү тээвэрлэж эхэлснээс хойш 100 гаруй жилийн түүхийг бүтээжээ. Байгалийн ийм их баялагтай болохоор иргэдийнх дийлэнх нь түүнийгээ түшиглэж амьдардаг учир дүүрэгтээ аж үйлдвэрийн шинэ парк байгуулах зорилт дэвшүүлсэн байна.

Ингэснээр барилгын 40 гаруй жижиг дунд үйлдвэр ашиглалтад орж, тэр хэрээр ажлын байр нэмэгдэнэ гэж тооцжээ. Энэхүү зорилт биеллээ олох боломж тун ойрхон байгааг налайхчууд олж харсан байна. Нүүрс боловсруулах, нийлэг хий, шатахуун орлох бүтээгдэхүүн гаргах, сэргээгдэх эрчим хүчний нөөцөө ашиглах төслүүдийг дэмжинэ хэмээн мөрийн хөтөлбөртөө тусгасан М.Энхболдыг дүүргээрээ дэмжихээр шийдсэн нь налайхчуудын хэлсэн үг, санал бодлоос харагдаж байлаа. Нөгөө талаар Хан Хэнтий, Горхи, Тэрэлж зэрэг байгалийн цогцолбор газарт тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамгийн боломжтой бүс нутаг юм. Тэгвэл “Монгол төр-Монгол гэр” мөрийн хөтөлбөрт аялал жуулчлалыг бүс нутгийн онцлогт тохируулж бүсчлэн хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар тусгасан нь М.Энхболдыг дэмжих бас нэгэн үндэслэл болж байна. Тухайлбал, эрчимжсэн мал аж ахуй, хүнсний ногоо, жимс жимсгэний мод голлон тариалах газар тариаланг хөгжүүлэх бүрэн боломжтой. Энэ чиглэлд хэрэгжүүлэх төрийн бодлого түүний мөрийн хөтөлбөрт багтсан нь дүүргээрээ дэмжих бас нэг шалтгаан аж. Улстөржилтөөс ангид, олон тулгуурт гадаад харилцааг бий болгож, эв тэгш, сайн хөршийн найрсаг харилцааг бэхжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан талаар М.Энхболд ярихад цугласан олон нэгэн зэрэг алга ташиж, дэмжиж буйгаа илэрхийллээ. Учир нь, энэ дүүрэг Чех, Солонгос, Сингапур, БНХАУтай гадаад харилцаатай бөгөөд энэ хүрээнд ойрын хугацаанд 3000 айлын иж бүрэн орон сууцны хороолол барихаар төлөвлөсөн аж. Ийм л байдлаар салбар бүрт чиглэсэн бодлого, зорилтыг мөрийн хөтөлбөртөө багтаасан нь нэр дэвшигчийн хувьд давуу тал болж, уулзалт хийсэн дүүрэг, аймаг бүр багаараа дэмжихээ илэрхийлж буйн нэгэн жишээ налайхчууд юм.

## Нэр цэвэр С.Ганбаатарыг дэмжинэ гэдгээ илэрхийлэв



МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатар Хан-Уул дүүргийн иргэд сонгогчидтой уулзлаа. Сонгогчид С.Ганбаатарыг 27 жилийн МАНАН-гаас салгаж чадах хүн, МАНАН-гийн бүлэглэлд цаашид итгэхгүй гэдгээ илэрхийлж байв. Сайнхүүгийн Ганбаатар энэ үеэр “Ард түмний дэмжлэг хүчирхэг. Тэдэнд ямар хүч байдгийг сүүлийн өдрүүд хүмүүс ойлгож байна. Эрх баригчид МАХН-аас нэр дэвшигчийг басаж, дорд үзэж байсан тал бий. Харин одоо тэд айж эхлэж байна. Ухаан алдатлаа айж байна. Монголын ард түмэн бид бяртай хүчтэй. Бусдад мөнгө байж болно. Харин бидэн Хан-Уулчууд байгаа гэдгийг батлан харуулцгаая бүгдээрээ” гэлээ. Ажилчны раойн хэмээн тухайн үедээ нэрлэгдэж байсан Монгол Улсын томоохон бүс байсан Хан-Уул дүүрэгт олон мянган ажилчид социализмын үеийн бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж байсан билээ. Харин хувьчлалаар үйлдвэрүүд бүгд алга болсон. Энэ бүхнийг бүтээн хийж өгсөн ахмад буурлууд өнөөдөр амьдралын баталгаагүй зутруухан амьдарч байна. Тус дүүргийн сонгогчид “Энэ сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатарыг дэмжиж байна. Нэр цэвэр, хийсэн зүйлтэй энэ хүнийг ирээдүйнхээ сайн сайхны төлөө тууштай дэмжинэ”гэдгээ илэрхийлж байв.

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out

# МЭРГЭЖЛЭЭ СОНГОХОД НЬ ЗӨВЛӨДӨГ ХЭМЭЭЛЭЭ



Н.БАТЗАЯА

Хүн бүр мэргэжил сонголт гэж томоохон шалгууртай нүүр тулдаг. Зарим хүүхдүүд бага байхаасаа эхлэн өөрсдийн хүсэл мөрөөдөл, цаашдын чиг хандлагыг тодорхойлчихсон байхад нөгөө хэсэг нь энэ талаар огт бодолгүй явсаар цаг нь тулахаар толгойгоо гашилгаж суух нь бий. Зарим нь ямар ч сонголт хийлгүй эцэг, эхийнхээ албан шаардлагаар мэргэжлээ сонгосон байдаг билээ. Үүнээс болж хүүхдүүд сургуулиа орхих, хичээлдээ явахгүй байх, дахин өөр мэргэжлээр суралцах зэрэг сөрөг үр дагавар гардаг. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Speak out” булангаараа эцэг, эхчүүдтэй уулзаж “Та хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлдөг үү”, “Засгийн газраас гаргасан эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг мэдэх үү” гэх асуултад хариулт авлаа.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*



### Х.Наранцацрал: Зөвхөн хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг л чухалчилна

*/Дорнод аймгийн иргэн/*

-Би эрэгтэй хүүхэдтэй. Олон хүний туршлагыг сонсоход эрэгтэй хүүхдийн шийдвэрт нөлөөлөөд хэрэггүй гэдэг юм билээ. Миний ойр дотны хүмүүс ч энэ замыг туулсан. Эрэгтэй хүүхэд өөрийнхөө шийдвэрээр л явдаг. Хэдийгээр ээж, аавынхаа хүссэн мэргэжлээр суралцсан ч төгсөөд мэргэжлээрээ ажиллахгүй байх тохиолдол бий. Тиймээс би хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлөхгүй. Өөрийнх нь хүссэнээр байлгана гэж боддог. Манай хүүхэд эрхзүйн чиглэлээр суралцах сонирхолтой. Мэргэжлээ сонгочихсон. Би тухайн мэргэжлийн цалин, ажлын байрны олдоц гэх мэтчилэн эрэлт хэрэгцээг хардаггүй. Зөвхөн хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг л чухалчилна. Өөрөө хэн болмоор байна түүнийг нь л хүндэтгэнэ.



### Б.Дэлгэрмаа: Тулган шаардахаас илүү зөвлөх хэрэгтэй

*/Хан-Уул дүүргийн иргэн/*

-Манай хүүхэд 15 настай, наймдугаар ангид сурдаг. Одооноос зөвлөгөө өгөх байдлаар нөлөөлье гэж боддог. Тухайлбал, манай хүүхэд хүнд хэрэггүй мэргэжил сонирхоод байгаа юм. Харин би хүүдээ инженер, эдийн засагч гэх мэтчилэн цаашид өсч, дэвжих боломжтой мэргэжлийн санал болгодог. Яах вэ, бага байгаа учраас алсын хараа, ирээдүйд ямар мэргэжил өөрт нь хэрэг болохыг сайн мэдэхгүй байна. Тиймээс ээж, аав нь чиглүүлж өгөх ёстой гэж боддог. Гэхдээ шууд чи тийм мэргэжилтэй бол гэж тулган шаардахаас илүү зөвлөх хэрэгтэй. Мэргэжил гэж юу вэ, хүний амьдралд мэргэжил яагаад чухал, үнэ цэнэтэй вэ, мэргэжлээ зөв сонгосноор юунд хүрч болох зэргийг тайлбарлаж өгөх нь зөв гэж боддог. Энэ нь ахлах ангид ороод мэргэжлээ сонгоход нь жаахан ч гэсэн тус дэм болох болов уу. Өөрөөр хэлбэл, одооноос суурийг нь зөв тавиад өгөх хэрэгтэй гэсэн үг. Ахлах ангид орохоор нь хүсэл мөрөөдлийг нь сонсох хэрэгтэй. Хүн өөрийнхөө огт сонирхолгүй зүйлийг огт сурдаггүй шүү дээ. Харин өөрийнхөө сонирхсон зүйлийг маш их хичээж сурдаг. Эцсийг нь үзэхийг боддог. Сонирхоогүй зүйлийг нь хийлгэх гээд мянга албадаад ч нэмэргүй. Сүүлийн хэдэн жил ойр орчмын хүмүүс их, дээд сургуульд элсэх ороогүй болохоор эрэлттэй мэргэжлийн жагсаалтын талаар сайн мэдэхгүй юм. Би хүүдээ яагаад инженер мэргэжлийг зөвлөсөн бэ гэвэл, сүүлийн үед техник, технологи эрчимтэй хөгжиж байна. Энэ чиглэлээр суралцвал хүүхэд маань ч өөрөө өсч, хөгжих боломжтой. Хэзээ ч сурсан оройтохгүй мэргэжил гэж боддог.



### Ө.Отгон: Хүүхдүүдийнхээ мэргэжил сонголтод огт нөлөөлдөггүй

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Би гурван хүүхэдтэй. Хоёр хүүхэд маань оюутан, нэг нь зургадугаар анги төгслөө. Би хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлдөггүй. Манай хоёр хүү өөрсдийнхөө сонирхлын дагуу мэргэжлээ сонгож, суралцсан. Хоёр хүү маань барилгын мэргэжлээр суралцдаг. Манай дүү барилгын инженерлдээ.Хүүхдүүдзуныхаа амралтаар барилгад ойр зуурын ажил хийдэг байлаа. Одоо нэг нь барилгын архитектур, нэг нь барилгын коллежийг төгсөөд техникчийн ангид суралцаж байна. Өнгөрсөн жил хамгийн эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг харсан. Инженер, бага ангийн багш, уул уурхай, хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлүүд орсон санагдаж байна. Ойр дотны ах дүү, найз нөхдийн хүүхдүүдийг харахаар “Чи эмч болчих. Айлд нэг эмч байхгүй бол болохгүй. Чи багш бол” гээд хүчээр тулган шаардаж мэргэжлийнх нь сургуульд оруулчихдаг. Түүнээс болж хүүхдүүд нь сургуулиа төгсөлгүй дундаас нь хаясан тохиолдол олон бий. Тийм учраас би хүүхдүүдийнхээ мэргэжил сонголтод огт нөлөөлдөггүй. Өөрсдөө л сонго гэдэг. Миний хүүхдүүд өөрсдөө шалгалтаа өгч, сургуульдаа бүртгүүлсэн.



### Х.Эсэнгүль: Тодорхой хэмжээгээр нөлөөлөх хэрэгтэй

-Манай хүүхдүүд их сургуульд орох болоогүй. Хүү минь 11, охин маань найман настай. Гэхдээ миний бодлоор хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлөх хэрэгтэй гэж боддог. Хэн нэгнээс зөвлөгөө аваагүй, зөвхөн өөрийнхөө хүсэл мөрөөдлөөр яваад буруудсан хүүхдүүд олон бий. Сургуулиа төгсчихөөд ажлын байр олдохгүй байхад мянга мөрөөдөл яриад яах билээ. Манай улсад хүсэл мөрөөдлөө биелүүлэх нөхцөл, боломж нь ямар билээ гэдгийг бодолцох хэрэгтэй. Гол нь төгсөөд ажлын байртай, цалинтай л байх хэрэгтэй. Тэгэхгүй бол дөрвөн жил аав, ээжийнхээ мөнгийг үрчихээд ажилгүй байвал хэцүү шүү дээ. Манай улсад их, дээд сургууль төгсчихөөд ажлын байргүй хүн олон байдаг. Үүний нэг шалтгаан нь мэргэжлээ буруу сонгосонтой холбоотой болов уу гэж боддог юм. Нэг хэсэг бүгд хуулийн мэргэжлээр суралцсан. Анагаахаар ч сурсан. Одоо хуулийн байгууллагад ажил олдохгүй, хахууль нь тэнгэрт хальсан өндөр. Тиймээс хүн мэргэжлээ сонгохдоо маш зөв сонгох хэрэгтэй. Эцэг, эхчүүд хүүхдүүддээ ч хэлэх хэрэгтэй. Би хүүхдүүдийнхээ ирээдүйн амьдралд нь хэрэгтэй мэргэжил сонгоход нөлөөлнө.



### Б.Бат-Эрдэнэ:Мэргэжил сонголтод уян хатан хандах ёстой

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Би хувьдаа мэргэжил сонголтод уян хатан хандах ёстой гэдэг зарчмыг баримталдаг. Тэр дундаа хүүхдийнхээ мэргэжил сонголтод. Миний хувьд мэргэжил сонголтод нь шууд нөлөөлдөггүй. Тэгэх нь буруу гэж боддог. Яагаад гэвэл хүүхдийг ямар ч өөрийн гэсэн үзэл, бодол, хүсэл мөрөөдөлгүй болгочихдог. Бид хүүхдүүдээ үргэлж дагаад явж чадахгүй шүү дээ. Тэднийг биеэ дааж хариуцлагатай том шийдвэрийг гаргаж сургах хэрэгтэй. Үргэлж өмнөөс нь шийдвэр гаргаад байвал ажлын байранд гарсан ч бусдын амыг л хардаг болчихно шүү дээ. Энэ талаар би нэг удаа уншиж байсан юм байна. Хүүхэд өөрөө шийдвэр гаргаж сурах нь чухал. Биеэ дааж сурахад нь нөлөөлнө гэж. Үүнийг Монголчууд ойлгох хэрэгтэй. Манайхан чинь хэт бие биенийхээ асуудалд оролцдог. Бид насанд хүрсэн ч аав, ээж минь яасан бэ, юу болсон бэ гээд санаа тавьсаар л байдаг. Тэгэхээр бид хүүхдээ бие даалгаж, амьдарлын чухал сонголтыг өөрсдөөр нь хийлгэх ёстой. Манай охин дизайнер болно гэдэг. Магадгүй өөрийн хүсэл мөрөөдлийн төлөө яваад том амжилт гаргах ч юм билүү. Бид түүнийг дэмжиж өгөх л хэрэгтэй байгаа юм.

# ДЭЛХИЙ

## Брексит эхэллээ

Их Британи улс Европын холбооноос гарах эсэх тухай асуудлыг хэлэлцэхээр тус холбооны Брюссель дэх төв байранд Брекситийн зөвлөгөөн эхэлжээ. Жилийн өмнө Британийн иргэд Европын холбооноос гарах санал өгч байсан юм. Хурлын үеэр Их Британийн Брексит хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга Дэвид Дэйвис иргэдийн ашиг сонирхолд нийцсэн зэрэг шийдвэрт хүрэхийг зорьж байгаагаа мэдэгдсэн байна.

Их Британи худалдааны асуудал болон Европын холбооноос гарах эсэх тухай шийдвэрт хүрэх сонирхолтой байгаа бол Европын холбоо зөвхөн Брекситийн асуудалд төвлөрөх шаардлага тавьж буй юм байна. Дээрх асуудалтай холбоотой эцсийн шийдвэр 2019 оны гуравдугаар сард гарах ёстой боловч Европын холбоо бусад гишүүн орнуудын зөвшөөрлийг авах үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотойгоор 2018 оны арваннэгдүгээр сард шийдвэрээ гаргах төлөвлөгөөтэй байгааг “Эн Эйч Кэй” мэдээлжээ. Энэ сарын 8-нд болж өндөрлөсөн Их Британийн ерөнхий сонгуулиар тус улсын эрх баригч Консерватив нам олонхийн суудлаа алдсан нь Брекситийн асуудалд хэрхэн нөлөөлөхийг олон улс ажиглаж буй юм.



## ХОЙД СОЛОНГОСТ ХОРИГДОЖ БУЙ ИРГЭДЭЭ СУЛЛАХЫГ ШААРДЛАА

Б.ДАВАА

Хойд Солонгост суртал ухуулгын постер хулгайлсан гэх хэрэгт холбогдон 15 жил хүнд хөдөлмөр эрхлэх ял сонссон америк оюутан долоо хоногийн өмнө ухаангүй байдалтайгаар эх орондоо ирсэн билээ. Гэвч, ирснээсээ хойш ердөө зургаа хоногийн дараа таалал төгссөн байна. Жил гаруйн өмнө БНАСАУ-д баривчлагдсан 22 настай Отто Уармбьерыг эрүүл мэндийн шалтгааны улмаас суллаж, энэ сарын 13-нд АНУ руу буцаасан байдаг. Тухайн үед талийгаач комд байсан бөгөөд АНУ-ын Охио мужийн Синсиннатигийн эмнэлэгт эмчилгээ хийлгэж байжээ. Тархиндаа ноцтой гэмтэл авч, хүмүүстэй харилцах боломжгүй болсон Отто төд удалгүй буюу даваа гарагийн 14:00 цагийн үед эцэг эхийнхээ гар дээр амьсгал хураасан байна.

Отто Уармбьер Виржиниагийн их сургуулийн оюутан байжээ. Гэвч өнгөрсөн оны нэгдүгээр сард Пхеньяны зочид буудлын өрөөнөөсөө улс төрийн суртал ухуулгын агуулгатай постерыг хулгайлсан гэх хэргээр нисэх онгоцны буудлаас баривчлагдаж, хүнд хөдөлмөр эрхлэх ял сонссон байдаг. Хойд Солонгосын Засгийн газар болсон хэргийн талаар “талийгаачид өнгөрсөн жилийн гуравдугаар сард ял ногдуулсны дараа ботулизм өвчнөөр өвчилсөн. Тухайн үед нойрсуулах эм хэрэглэсний дараа комд орсон” гэж тайлбарлажээ. Гэвч “Хүүгийн минь биеийн байдал муу байгааг мэдсээр байж эмнэлгийн тусламж үзүүлээгүй” гэж Умард Солонгосын шоронгийн албаны хүмүүсийг О.Уормбиерын эцэг буруутгаж байна. Тэгвэл одоогоор АНУ-ын зарим улстөрчид Пхеньянд хоригдож буй иргэдээ яаралтай суллахыг шаардаж эхэлсэн байна. Тухайлбал, Шинэ Мексик мужийн экс захирагч Билл Ричардсон талийгаачийг хоригдож байхад Хойд Солонгосын тусгай элч 20 удаа АНУ-ын албаныхантай уулзсан хэдий ч, нэг ч удаа биеийн байдал, эрүүл мэндийнх нь талаар дурьдаж байгаагүйг онцолжээ. Улмаар түүнд тохиолдсон шиг эмгэнэлт явдал одоо ч, Хойд Солонгост хоригдож буй Америкийн гурван иргэнд тохиолдож магадгүй тул суллахыг шаардаж эхэллээ. Тодруулбал, Өмнөд Солонгост төрсөн АНУ-ын иргэншилтэй 62 настай Ким Дон Чул, профессор Тони Ким, Ким Хак Сон нар тус улсад ял эдэлж байгаа аж. Ким Дон Чулын тухайд тагнуулын хэргээр 2016 оны дөрөвдүгээр сард мөн л 10 жил хүнд хөдөлмөр эрхлэх ял сонсч байжээ. Харин Тони Ким буюу Ким Сан Дук профессор энэ оны дөрөвдүгээр сард баривчлагдсан. Гэхдээ түүнийг ямар үндэслэлээр саатуулсан нь одоогоор тодорхойгүй байгаа билээ. Ким Хан Сонгийн хувьд Тони Кимийн адил Пхеньяны их сургуульд ажиллаж байсан ч, төрийн эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулсан гэх үндэслэлээр нэг сарын өмнө баривчлагдсан юм. Болсон үйл явдалтай холбоотойгоор АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп өөрийн байр сууриа илэрхийлээд амжжээ. Тэрбээр Хойд Солонгосыг “Харгис дэглэм”-тэй хэмээн буруутгасан байна. Мөн “Муу зүйл болжээ. Юу гэвэл Отто нас барсан байна. Цэл залуухнаараа хорвоог орхилоо. Түүний гэр бүлийнхэнд гүн эмгэнэл илэрхийлье” хэмээн мэдэгдсэн байна. Дашрамд дурьдахад, Хойд Солонгост АНУ-ын иргэдийг жуулчлан аялуулдаг “Young Pioneer Tours” байгууллага үйл ажиллагаагаа түр зогсоожээ. Тус компанийн төлөөлөгч “Ийм эмгэнэлт төгсгөлтэйгөөр Хойд Солонгост баривчлагдсан тохиолдол эдүгээг хүртэл гарч байгаагүй” гээд “Америкчууд Хойд Солонгост айлчлахад учрах эрсдэлийг тооцоход өндөр үзүүлэлттэй гарсан. Тиймээс америк иргэдэд зориулсан Хойд Солонгост хийх аялалын маршрутыг тодорхойгүй хугацаагаар цуцаллаа” хэмээн тайлбарласан байна.

БНХАУ-ын Шаньси мужийн Шьанд төвтэй “Young Pioneer Tours” байгууллагыг 2008 онд Их Британийн иргэн байгуулж байсан бөгөөд адал явдал хайгч жуулчдыг Хойд Солонгос, Иран гэх мэт “ээжтэйгээ хамт явж болохгүй” эрсдэлтэй газрууд руу аялуулдаг байна.

## 200 сая сонгогчийн мэдээлэл алдагджээ

АНУ-ын Бүгд Найрамдах намтай гэрээгээр ажиллаж байсан, өгөгдөлд дүн шинжилгээ хийдэг “Deep Root Analytics” компани алдаа гаргасны улмаас 200 сая орчим америк сонгогчийн хувийн мэдээллийн өгөгдлийн сан интернет сүлжээнд ил болжээ. Энэ тухай даваа гарагт “The Hill” сонинд бичсэн байна. Мэдээлэл алдагдсаныг компьютерын аюулгүй байдлын асуудал эрхэлдэг “UpGuard” байгууллагын шинжээч Крис Викери илрүүлжээ. Тэрбээр “Ашигласан дискний орон зайгаас харвал, энэ нь миний мэдэхээр, мэдээлэл алдагдсан хамгийн ноцтой тохиолдол байсан” гэж ярьсан байна. Түүний хэлж буйгаар, 25 террабайтын хэмжээтэй мэдээллийн санг нууц үгийн хамгаалалтгүйгээр “Amazon” компанид харьяалагддаг өгөгдлийн үүлэн санах ойд байршуулсан байжээ. Уг мэдээллийн санд 198 сая америкчуудын овог нэр, гэрийн хаяг, компьютер загварчлалын аргаар гаргасан дүн шинжилгээний мэдээлэл, улс төрийн ямар нэгэн асуудлаарх байр суурьтай холбоотой мэдээллүүд байжээ. Тухайлбал, 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Барак Обамаг дэмжих, өнгөрсөн онд Доналд Трампыг дэмжихтэй холбоотой мэдээллүүд ч байсан байна. 2016 оны сонгуулийн кампанит ажлын дүнгийн талаарх өгөгдлийн санг хамгийн сүүлд өнгөрсөн нэгдүгээр сард шинэчилсэн бөгөөд үүний дараа санаандгүй байдлаар олон нийтэд ил болсон нь энэ юм. “The Hill” сонинд бичсэнээр, хүссэн хүн бүр эдгээр мэдээлэлтэй танилцах бүрэн боломжтой болсон байв. Харин К.Викери мэдээлэл алдагдаж байгааг энэ сарын 12-нд илрүүлж, алдаа гаргасан компани болон тохируулагч агентлагуудад мэдэгдсэнээр алдааг засварлажээ. АНУ-ын сонгогчдын хувийн мэдээлэл алдагдсан энэ тохиолдол нь цар хүрээгээрээ бусад орнуудаас илүү ноцтой гэдгийг эх сурвалж онцолсон байна. Тухайлбал, 2016 оны дөрөвдүгээр сард интернетэд 93 сая мексикчүүд, 55 сая филиппинчүүдийн хувийн мэдээллийн өгөгдлийн сан ил болж байжээ.

## Халдлага үйлдэгчийн нэрийг зарлав

Их Британийн нийслэл Лондон хотын лалын шашны сүмийн ойролцоо энэ сарын 19-ний өдрийн 00.20 цагийн үед халдлага гарсан билээ. Бүхээгтэй машин жолоодсон этгээд мөргөл хийгээд гарч ирсэн явган зорчигчдыг хөөн дайрч эхэлсний улмаас нэг хүн нас барж, арван хүн гэмтэж бэртсэн юм. Тэдний найм нь одоо эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна. Халдлага үйлдэгчийг эдүгээ цагдаагийн байгууллага саатуулаад байна. Харин гэрчүүдийн мэдээлснээр сэжигтэн “Лалын шашинтнуудыг бүгдийг нь хөнөөмөөр байна” хэмээн хашгирч байсан гэнэ. Энэ хэрэг Лондонгийн хойд этгээдийн Финсбури парк дахь сүмийн ойролцоо болсон юм. Тэгвэл өчигдөр бүхээгтэй машины жолооч хэн болохыг цагдаагийн газраас зарлажээ. Тодруулбал, халдлагыг Даррен Осборн гэгч 47 настай эрэгтэй болохыг Их Британийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлжээ. Тэрбээр Уэльсийн нийслэл Кардифф хотын оршин суугч юм байна. Сэжигтнийг террорист халдлага үйлдсэн гэж буруутгаж, саатуулаад байгааг цагдаагийн газар мэдэгджээ. Үүнтэй холбоотойгоор Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй тус халдлагыг лалын шашинтнуудыг үзэн ядах сэдлээр үйлдсэн болохыг цохон тэмдэглэсэн байна.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр.
**Тендер шалгаруулалтын нэр:** [Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Хөдөөгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон өргөн зурвасын сүлжээ байгуулах /Бүх сумд/” ажлын зураг төсөл боловсруулах, барилга усралтын ажил]-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.
**Тендер шалгаруулалтын дугаар:** 2017-ТГН010

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Хөдөөгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон өргөн зурвасын сүлжээ байгуулах /Бүх сумд/” ажлын зураг төсөл боловсруулах, барилга усралтын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000,0 (Тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх стой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.**Үүнд:**

- Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.
- Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай: Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

Б ангилал: Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ

**Төрөл:**

-Гадна холбооны кабель, шугам угсралт, суурилуулалт, засвар

-Дотоод холбооны сүлжээний суурилуулалт, засвар

-Барилгын дотор холбооны монтаж, угсралт суурилуулалт

-Цамхаг түүн дээрхи холбооны тоног төхөөрөмж угсралт, суурилуулалт, засвар

3.2.1 0.4-10 КВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

1.2.2. 1-16 давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (ПОС, ПОР, ППР) зураг төсөл, Барилга байгууламжийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж ( резервуар, бункер, силос, цамхаг, яндан, антенна гэх мэт)-ийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (ПОС, ПОР, ППР)

2.1.3. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1- 16 давхар хүртэл), Цамхаг, тулгуур, түшиц хана, яндан, антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон, төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил

Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баталгааны дүн: 6,000,000 (Зургаан сая) төгрөг

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 30- минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө (мэргэжилтэн С.Бат-Өлзий, Утас:70518123, 89151515)]**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр.
**Тендер шалгаруулалтын нэр:** [Аймгийн төвийн доторхи авто замын засвар, арчлалт, шинэчлэлт ажил]-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОНӨГ2017/02025

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос:“Аймгийн төвийн доторхи авто замын засвар, арчлалт, шинэчлэлт ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000,0 (Тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.
- Сүүлийн 3 жилийн аль нэг жилийн хугацаанд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

3.7.1.1.6. ЗБ-1-6 /3 хүртэл км/ Хатуу хучилттай авто зам барих

3.7.4.1 ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил /Авто замын засвар арчлалтын ажил/

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баталгааны дүн: 6,000,000 (Зургаан сая) төгрөг

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 10 цаг 30-минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө (мэргэжилтэн С.Бат-Өлзий, Утас:70518123, 89151515)]**

# ЦАГ ҮЕ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР · Schweizerische Eidgenossenschaft · Confédération suisse · Confederazione Svizzera · Confederaziun svizra · Swiss Agency for Development and Cooperation SDC · Швейцарийн хөгжлийн агентлаг · THE WORLD BANK IBRD • IDA | WORLD BANK GROUP · МУНЭХБТ · МНЭММН · ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ ШИЙДЭЛ ТББ

# Б.СОСОРБАРАМ: СЭТГЭЛГЭЭГ ДАГАЖ АРГА БАРИЛ ӨӨРЧЛӨГДӨНӨ



Т. БОЛДБААТАР

*Нийслэлийн гурван дүүрэг, 10 аймагт хэрэгжиж байгаа “Монгол Улсад нийгмийн эргэх хариуцлагыг бэхжүүлэх” төсөл хэрэгжиж буй. Уг төслийн хүрээнд “Онош” төрийн бус байгууллага Говьсүмбэр аймагт “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь” төслийг хэрэгжүүлж байгаа билээ. “Онош” төрийн бус байгууллага нь 2015 онд аймгийнхаа шилдэг төрийн бус байгууллагаар шалгарч байжээ. Тус төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Б.Сосорбарамтай ярилцлаа.*

**-“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь” төсөл Говьсүмбэр аймагт хэрэгжээд багагүй хугацаа өнгөрлөө. Юуны өмнө төслийн талаар танилцуулахгүй юу?**

-Манай аймгийн Эрүүл мэндийн салбарынхны хувьд завшаантай хэрэг. Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Монгол Улсад нийгмийн эргэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь” төслийн зөвлөх төрийн бус байгууллагаар Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгтэй хамтарч ажиллаад зургаан сар гаруй хугацаа өнгөрч байна. Санхүүжилтийн тухайд, гэрээнд зааснаас саатаж эхэлсэн ч төсөл нээлтээ хугацаандаа хийж, хоёрдугаар сарын эхээр оролцогч талууд санамж бичигт гарын үсэг зурж үе шаттай ажлуудаа хэвийн явууллаа. Төслийн үр шимийг хүртэх аймгаар сонгогдож холбогдох байгууллагаас хүмүүс ирж орон нутгийн эрүүл мэндийн салбарт тулгамдсан шийдвэрлэхэд хамтын хүч оролцоо нэн шаардлагатай асуудлаар хэлэлцүүлэг хийж эрэмбэлсэнээр их ажил эхэлсэн.

**-Төслийн гол зорилго, барьж ажилласан чиглэл юу байв?**

-Үйлчлүүлэгчдийн төлөөлөл иргэдтэй ярилцаад дүгнэж үзэхэд аймгийн нэгдсэн эмнэлэг, “Энхтусдэм” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага, мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлж буй байдал, хүрэлцээ хангамж, шатлал хоорондын үйлчилгээ гэсэн асуудалд анхаарлаа хандуулах нь зөв юм байна гэж шийдэхэд хүрсэн. Хэлэлцүүлгийн явцад олон эхтэй санал гарч байсан ч дээрхи хэдэн асуудал тунаж үлдсэн нь бидний дүгнэлттэй онож нийцсэн байлаа. Хүлээгдэх үр дүн гол зорилго маань аймгийн эрүүл мэндийн салбар тэр дундаа нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн ажилтнууд түүнчлэн үйлчлүүлэгчдийн сэтгэлгээ хандлага, өдөр тутмын үйл ажиллагааны арга барил, харьцаанд ахиц өөрчлөлт гарахад байгаа юм. Энэ цаг үе бол үйлчилгээний зуун гэдгийг ойлгож эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрсдөө анхаарах төдийгүй үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл зүйг эмчилж ажиллах шаардлагатай байгаа юм.

**-Уншигчдад ойлгомжтой байх талаас нь нийгмийн эргэх хариуцлага, иргэдийн онооны картын ойлголтыг тайлбарлаж өгөхгүй юу?**

-Нийгмийн эргэх хариуцлага нь төрд хариуцлага тооцох, хариуцсан тайлагналтыг сайжруулах зорилго бүхий иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санаачилга болон энэхүү хүчин чармайлтыг дэмжсэн төр,хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, донор байгууллагуудын үйл ажиллагаа нэг талаар олон нийтийн сонирхлын үүднээс төрд хяналт тавих, засаглалын тэнцвэрийг бий болгох, засаглалын нэмэлт механизм гэж үздэг. Нийгмийн эгэх хариуцлага нь зохион байгуулалттай, чадваржсан иргэд, төрийн нөөцийн зохистой зарцуулалт болон нийтийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тэдний эрхийг хамгаалахын төлөө төрийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцох үйл явц гэсэн үг. Иргэдийн онооны карт нь олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналт үнэлгээний арга хэрэгслэл бөгөөд үйл ажиллагаа үйлчилгээний мониторингийн хамгийн түгээмэл аргачлал. Иргэдийн тайлангийн карт, олон нийтийн мониторинг, нийгмийн аудит зэрэг аргачлалуудын холимог хэлбэр гэж үздэг. Бэлтгэл ажил, орц гарцыг хянах матриц, үйлчилгээ хүртэгчдийн онооны карт, үйлчилгээ үзүүлэгчдийн өөрийн үнэлгээ, хоёр талын нүүр тулсан уулзалт, үнэлгээний үр дүнг олон нийтэд түгээх, сурталчлах, нөлөөлөх үе шатуудтай.

**-ИОК-ын зургаан үе шатыг хэрэгжүүлсэний дараах үнэлгээ, сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?**

-Ер нь төсөл маань бараглаж байгаа. Аймгийн засаг даргын захирамжаар төсөл хэрэгжилтийг зохион байгуулах долоон хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдсон. Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөн иргэд үйлчлүүлэгчдийн дунд төслийн тухай ойлголт өгөх, сурталчлах ажлыг удаа, дараа явуулсаны үр дүнд үл ойлголцох, эсрэгцэх байдал үүсээгүй нь төсөл урагштай хэрэгжихэд тус дэм болж өгсөнийг дурдах нь зүйтэй. Төслийн багийнхан энэ хугацаанд 1300 гаруй хүнтэй биечлэн уулзаж, 116 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ёс зүйн сургалт явуулж зөвхөн нэгдсэн эмнэлэгт гэхэд 11 асуулттай тандалт суурь судалгааг 500-аад хүнээс авсан. Ер нь 90 жилийн түүхтэй энэ салбарт анх удаа ажлын байрны ийм үнэлгээ хийсэн болохоор цочирдох байдал ажиглагдсан. Урьд өмнөх богино хугацааны төслүүдтэй адил зөвхөн техник, тоног төхөөрөмж, аппарат нийлүүлж хөдөлмөр хөнгөвчлөх, үйлчилгээний дэвшилтэт стандарт нэвтрүүлэх төдий биш өдөр тутмын үйл ажиллагааны зан төлөв, тогтсон хандлага, баримжааг засаж өөрчлөх нэг үгээр “толгойтой ажиллах” сар жилийн уртад үр дүн нь гарах төсөл шүү дээ. Бодит байдлын үнэлгээ, иргэний онооны картаар үнэлэх ажлыг маань аймаг сумын ЗДТГ, агентлагууд иргэд, салбарынхан ойлгож сайн дэмжиж оролцсон. Нэр, уснаасаа ч тодорхой. Өнөөдрийн төвшинд Говьсүмбэр аймагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэр зэрэг хүртээмжтэй, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага ямар байна вэ гэдэгт аль болох шударга, ил тод нүдэн дээр нь үнэлүүлж, нүүр тулж уулзаж ярилцах эргэн тайлагнах зарчмаар ажилласан.

**-Өөрсдийнхөө нэр төр, эрх ашиг, өргөсөн тангарагтай харшилж байна гэх эмзэглэл хандлага тохиолдов уу?**

-Харьцангуй гайгүй. Гэхдээ энэ салбарын дотоод ажлын уялдаа холбоо санаснаас сул, мэдээллийн хүртээмж хүлээн авалт тааруу байсан тал бий. Хэтэрхий онгон дагшин заримдаа ч догшин байдал ажиглагдсан, дийлэнх иргэдэд биш. Ухаандаа, иргэд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэмэр болохоор ажиллаж байгаа төслийн багийнхан үнэлээчдийг хууль хяналтынхан шиг ойлгох, хуучин тогтолцооны ардын хянан шалгах байгууллагатай энэ зэрэгцүүлэх, элдэв гомдол, мэдээлэл өгөх, хэт нэг талыг барих өөрийнхөө ганцхан удаагийн үнэлэмжээр хандах явдал мэр сэр, тохиолдсон. Ер нь дөрвөн жил ажиллаж байгаа шинэ тутам эмч ёс зүйгээ эрхэмлэж явахад 40 жил ажилласан гэчихээд үйлчлүүлэгчийн зүгээс гомдол шүүмжлэл сонсч хэл ам удах жишээний. Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн ёс зүйн хороо, багийг “стандарт”-аар нь ажиллуулж хэвшвэл тун сайн үр дүн гарч болмоор санагдалаа.

**-Төсөлд ажиллаж байх хугацаанд олж авсан сургамжтай зүйл юу байв?**

-Мониторинг гэдэг ёс зүй дээд хэмжээгээр шаардагдах амаргүй ажил юм билээ. Хэн нэгэн эмч, аль нэгэн тасгийн ажлын юухан, хээхнийг гоочлох, заавал алдаа дутагдал олохын тулд үндэслэлгүйгээр хардаж, сэрдэх, улыг нь шагайх, мууг нь цоллох аргачлал биш гэдгийг энэ салбарын хувьд үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгч хэн, аль нь харилцан ойлгосон болов уу. Иргэдийн ухамсарыг дээшлүүлэх, нэхэх байр суурь хандлагыг өөрчлөхийн тулд ил тод мэдээлэл маш чухал гэсэн нэгдсэн дүгнэлтэд хүрлээ.

**-Дэд төслийг хэрэгжүүлэх явцад гарсан онцлох дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярихгүй юу?**

-Монголын уран сайхны “Сэрэлт” киноны орос доовтор шиг ажиллаж чадах, эс чадах байх л хэрэг гэж үзэж боломгүй эзэмшсэн мэргэжил, өргөсөн тангараг, хүлээсэн үүрэг байгаа хойно ёс зүйтэй, үнэнч байгаа мэдлэг, ур чадвар, туршлагаа уудлаж ажиллах нь зүйн хэрэг. Энд нэг зүйлийг онцлох нь зүйтэй. ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн хяналтын хорооны орлогч дарга Д.Баярмаа сургалт удирдахдаа “Үндэсний хэмжээний жишиг, шилдэг хувийн хэвшлийн ГрандМед эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд чадвараас гадна харилцаа хандлагаа сайжруулж чадсандаа олон түмнээс үнэлэлт, хүндэтгэл хүлээж байгаа юм” гэж хэлж байсныг санаж ажиллах хэрэгтэй. ТББ-тайгаа хангалттай хамтран ажиллаж тэд маань чадавхижлаа гэхэд болно. Мөн иргэдийн эрүүл мэндийн байгууллагын талаарх үнэлэмж дээшиллээ. Төслийн хэрэгжилтийн явц байдлыг тайлагнах, танилцуулах үеэр гарсан санал дүгнэлтийн мөрөөр нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Шаардагдах бага сага, төсөвт нь төслийн зүгээс дэмжлэг үзүүлнэ гэж тооцсон. Зүрх судасны тасаг байгуулах санал, хүсэлт гарч үндэслэл тооцоогоо яамандаа танилцуулаад байна. Эцсийн дүндээ сэтгэлгээ дагаж арга барил, үйл ажиллагаа өөрчлөгдөнө гэдэгт орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд найдаж байна.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Цэцэрлэгийн барилга /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0189**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Цэцэрлэгийн барилга /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажлыг гүйцэтгэх** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.**
- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2015, 2016/**
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд /2015, 2016 он/ доод тал нь нэг удаа төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

**Зураг төсөл боловсруулах байгууллага нь:**
**Барилга, хот байгуулалтын яамны:**

- 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
- 1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- 1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

(10 кВ хүртэл )

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

- 1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:**
**Барилга, хот байгуулалтын яамны:**

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
- 2.1.2 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар/
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 15,380,000 /арван таван сая гурван зуун наян мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: **2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хүчинтэй байна.**

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 11 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот хурлын өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх тооцно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,**
**Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,**
**Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,**
**Утас: 75757807**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn**



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

## МУБИС-д багш шалгаруулж авна

**БАГШИЙН СУРГУУЛЬД:**

- Сурган сэтгэл судлалын багш -1
- Хөгжим арга зүйн багш -2

**БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ:**

- Сэтгэл судлалын багш -1

**УРЛАГ, БИЕИЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ:**

- Хөгжмийн онолын /гармони/ багш-1
- Найрал дууны багш -1
- Сагсан бөмбөгийн мэргэжлийн багш-1

тус тус шалгаруулж авна.

**ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:**

Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эв дүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.

**Бүртгэл:** *2017 оны 06 дугаар сарын 19-23-ныг дуустал МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.*

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:**

- CV монгол хэлээр
- Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар
- Төрийн албан хаагчийн анкет
- Ажил байдлын тодорхойлолт
- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- Цээж зураг 3 хувь /3*4/
- Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрийн хуулбар
- Шалгалтын хураамж 20.000 төгрөг тус тус авч ирнэ үү

**ШАЛГАЛТ:** 2017 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.

**Үүнд:**

1 Эхний ярилцлага
2 Мэргэжлийн шалгалт
3 Гадаад хэл /Англи, орос болон бусад хэл/
4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадвар
5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлууд
6 Нэгдсэн ярилцлага

***Жич:*** *Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу*

**Холбогдох утас: 311547, 99957309**
**Хөтөлбөрийн нэгдсэн алба**

# ЗАВСАРЛАГА

СУДЛААЧИЙН ҮГ

Монгол ёс уламжлалд ургийн бичиг, тэмдэглэл хөтлөх нь бүр эртний түүхэн гаралтай нь товчлон өгүүлбэл:

"Монголын нууц товчоо" номонд Чингис хааны дээд овог өвөг нь Тэмүүжингээс дээшхи Бөртэ-Чину хүртэлх 24 үеийг овог удмаар нь нэрсээр нь дэс дараалан бичсэн байдаг. Жишээ нь :

Чингис язгуур: Бөртэ-Чину гэргий Гуа-марал нар, Батичихан гэдэг нэгэн хөвгүүнийг төрүүлжээ.

Батицигааны хөвгүүн нь: Тамча

Тамчагийн хөвгүүн: Хорчир мэргэ

Хорчир мэргэний хөвгүүн нь Уужим-буурал гэх мэт нэрээр нь дараалж Есүхэй баатар, түүний хөвгүүн нь Тэмүүжин Чингис гэж бичсэн байдаг. Дээр үед нууц товчоог бичсэн хүмүүс Тэмүүжин Чингисээс дээшхи тэр 24 өвөг, удмын нэрийг ураг, удмын тэмдэглэлээр нь бичсэн нь тодорхой. Монголчууд эрт дээр үеэс "ургийн бичиг", "өрхийн түүхээ" хөтлөж, түүнийгээ өвөг, дээдэс, ахан дүүс, хамаатан садан, үр хүүхдүүд нь нарийн дагаж мөрддөг байжээ. Энэ уламжлал нь амьдралын үндсэн хоёр шаардлагаас үүсэн монгол хүний оюун ухаанаар үүсчээ. Энэ уламжлал нь бүр феодалын нийгмийн үеэс өмнө үүссэн байна.




# Ургийн бичгийн монгол түүх уламжлалаас

Нэгдүгээрт: Хамгийн гол зорилго нь цус ойртох аюулаас хамгаалдаг уламжлал юм. Монголчууд айл-өрх нэг бүрээрээ эрт дээрээс "ургийн" буюу "гэрийн үеийн бичиг" гэдэг тэмдэгтэй байжээ. Үр хүүхэд, залуусаа гэрлэх үед хоёр тал нь тэмдэглэлээ үзэж, удмаараа харилцдаг нарийн заншилтай байсан байна. Ер нь монгол уламжлал болон шинжлэх ухааны үндэслэлээр нь авч үзвэл, хүний цус ойртолт нь есөн үе дотор болдог байна. Орчин үед мөн адил шүү дээ. Монгол заншилд аль нэг эр, эм хоёр залуу ойртож харилцаа үүсгэж эхэлбэл хоёр талын аав ээж нь нөгөө тэмдэглэлээ үзэж , ахан дүүсийн мэдлэгээрээ шалгаж, хэрэв хоёр залуу есөн үе дотроо тав, зургаа долоо гэх мэт үе дотроо байвал шууд салган үерхэлийг нь зогсоодог нарийн ёс уламжлалтай байжээ. Хэрвээ үерхэгч хоёр есөн үе дотроо хамааралгүй бол шинэ айл гэр бүлийн ёсоор дэмждэг уламжлалтай байна. Энэ нь монгол хүний оюун ухаан эрүүл биеийн үндэс юм. Цус ойртсон хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд оюун ухаан мэдрэлийн согогтой, бие эрхтэн дутуу, ядууралтай байдаг нь тодорхой ажээ. Тэр нь өнөө үеийн тодорхой жишээ судалгаагаар нотлогддог. Монгол уламжлалд ураг-удам, ахан дүүсээ мэддэггүй хүнийг "Ойд төөрсөн сармагчин адил" гэж шоолон хэлдэг байжээ. Тэр нь үнэн Монгол төрийн олон зууны уламжлалаас үзвэл ургийн бичгээ:

"Төрийн ургийн бичиг"

"Гэрийн үеийн бичиг"

"Гэрээс гарсан тэмдэгт бичиг" гэж гурван үндсэн ангилалаар бичдэг байжээ.

Төрийн ургийн бичиг

Төрийн хаад, ноёд, ихэс дээдсээ удам, угсаагаар нь дээд албанд дэвшүүлэн томилдог учир тэр бичгээ "Ургийн бичиг" гэжээ. Ургийн бичгийн товч түүхээс дурьдвал: Хавт хасар, Бэлгүүтэй, Батмөнх "Даян хаан" жайлаар хун тайж Гэрсэнз нарын ургийн бичиг зэрэг олон бичиг байдаг. Эдүгээ Үндэсний Төв Архивт Цэцэн хаан аймгийн Шолой цэцэн хааны ургийн бичиг байдаг. Энэ бичиг нь: "Их дүгриг" хэмээх 5- 6 метрийн диаметртэй том цагаан давуун дээр монгол бичгээр бичсэн бичиг байдаг. Шолой цэцэн хааны /1577-1652/ нэрийг их дүгрэг давууны гол дунд нь монгол бичгээр бичээд

Хоёрдугаар тойрогт түүний 11 хөвгүүний нэрийг

Гуравдугаар тойрогт тэдний 54 хөвгүүний нэрсийг

Дөрөвдүгээр тойрогт тэдний 175 хөвгүүний нэрсийг

Тавдугаар тойрогт тэдний 474 хөвгүүний нэрсийг

Зургадугаар тойрогт тэдний 920 хөвгүүний нэрсийг

Долдугаар тойрогт тэдний 1127 хөвгүүний нэрсийг

Наймдугаар тойрогт тэдний 1427 хөвгүүний нэрсийг

Есдүгээр тойрогт тэдний 2214 хөвгүүний нэрсийг

Аравдугаар тойрогт тэдний 2296 хөвгүүний нэрсийг

Арваннэгдүгээр тойрогт тэдний 2595 хөвгүүний нэрсийг

Арванхоёрдугаар тойрогт тэдний 5917 хөвгүүний нэрсийг

Арвангуравдугаар тойрогт шинээр төрсөн 15 хөвгүүн /хүүхдийн/нэрсийг бичжээ. Эдүгээ ҮТА-т улсын номын санд хадгалагдаж буй. Монгол төрийн ургийн бичгүүд, Шолой цэцэн хааны ургийн бичиг зэрэг нь олон улсын аль ч архивт байхгүй.

**Товч тодруулга, тайлбар**

1. Айл өрхийн "гэрийн үеийн бичиг"-ийн эрт үед "модон самбар"-т ургаа модны салаа мөчир хэлбэрээр тэмдэглэдэг онцлогтой байжээ. Мөн даавуу, цаасан дээр зурах тохиолдол ч байсан аж.
2. Эртний аймаг , шавь, хошуудын айл нэг бүрт бичигтэн хүмүүс цөөн байсан учир: Гэрийн үеийн бичгээр тэмдэглэдэг тусгай бичигтэнийг орон нутгийн төр томилон ажиллуулдаг байжээ.
3. "Төрийн ургийн бичигт" зөвхөн эрэгтэйчүүдийг тэмдэглэдэг. Учир нь хаад, ноёд, түшмэд зэрэг төрийн албанд удмын эрэгтэйчүүдийг томилдог байв. Харин "Гэрийн үеийн бичигт" эрэгтэй, эмэгтэй, үр хүүхдийг нь бүгдийг нэрсээр нь тэмдэглэдэг заншил түүхтэй.

Монголчууд түүх уламжлалынхаа дагуу орчин үед л "Гэрийн үеийн бичиг"-ээ хөтлөдөг болмоор байна даа. Энэ нь бодлогоор зохицуулагдах асуудлын нэг билээ.

МУСГЗ, доктор профессор Г.НОРОВСАМБУУ

**2017-06-21**
**Утас: 353314**

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 25
Шөнө 11

Нөгөөдөр
Өдөр 28
Шөнө 12

Өдрийн зурхай

**ЗУНЫ ЭХЭН ХӨХӨГЧИН МОГОЙ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 04.53-20.54
**Үс засуулбал:** Өлзийтэй сайн



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

СОНИРХУУЛАХАД

## Баяр наадмын нээлтэд "Монголын сайхан орон" киноны ая эгшиглэнэ



Герман улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Штефан Дуппел өчигдөр Шадар сайд У.Хүрэлсүхтэй уулзаж, Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн "Монголын сайхан орон" киноны аяыг манай улсын талд хүлээлгэн өглөө. Шадар сайд Үндэсний Их баяр наадмыг зохион байгуулах комиссыг ахалж ажилладаг бөгөөд энэ удаагийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн "Монголын сайхан орон" киноны аяыг эгшиглүүлэхээр төлөвлөж байгаа аж. Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн "Монголын сайхан орон" киноны аяыг 1961 онд алдарт Дефа кино үйлдвэрийн симфони оркестрт бичүүлсэн боловч анхны партитур нь манай урлагийн сан хөмрөгт хадгалагдаж үлдээгүй байна. Тиймээс Дефа кино үйлдвэрийн архивт хадгалагдаж байгаа уг хөгжмийн партитурыг хувилан авч, Улсын баяр наадмын ёслолын үйл ажиллагаанд эгшиглүүлэх хүсэлтэй буйгаа Шадар сайд У.Хүрэлсүх ХБНГУ-ын талд илэрхийлээд байсан аж. Уулзалтын үеэр ХБНГУ-ын элчин сайд болон албаныханд зориулан, алдарт зохиолчийн "Жалам хар" аязыг эгшиглүүлж, Морин хуур хөгжмийг бэлэг болгон өгөв. Манай улс тус хөгжмийн зохиолын партитурыг хувилан авснаар хөгжмийн сан хөмрөг, архив баяжиж, Үндэсний их баяр наадмаар эгшиглүүлээд зогсохгүй Монголынхоо нэрт хөгжмийн зохиолчийн энэхүү бүтээлийг партитурын дагуу анх удаа албан ёсоор тоглох нөхцөл бүрдэх юм.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Slgmaa Maa



Сарандаваа гуай манай нутагт ирж мөнгөний тухай лекц уншаад л театр пиг хүнтэй. Янз янзын тарни уншаад ,түрийвчээр даллаад л бөөн юм болж болж за хоёр хүн гараад ир хүслийг нь биелүүлж өгье л гэлээ. Тэгсэн нэг ах,эгч хоёр гарлаа. Ахаас асуулаа.Хүсэл мөрөөдлөө хэл би биелүүлж өгье л гэсэн. Сарандаваа гуай.Тэгсэн ах харин би хоёр ихэр хүүтэй болмоор байна гэсэн чинь Сарандаваа гуай уурлаад наадах чинь чиний асуудал би мөнгөтэй холбоотой хүсэл биелүүлдэг гэж ирээд загнасан.Хүмүүс бөөн инээдэм болсон.Ид шидтэй гэхэд арай л бас хоёр ихэр хүү зохицуулж чадахгүй байлгүй дээ.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ГАН ЗҮҮ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ



Манай эмнэлэг дотор 5 цул, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван засалын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танд:
- Ган болон мөнгөн зүү, цахилгаан зүү
-Ханүүр, сам соруул
-Шарлага
-Бумба төөнө засал
-Халуун чулуу, давсан халуун жин засал
-Эмчилгээний цэгэн бариа
-Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ

Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/